



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 7 нэрийн нийт 160,152,055.00 (нэг зуун жаран сая нэг зуун тавин хоёр мянга тавин таван) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацаа үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоож Үндэсний геологийн албанд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, Үндэсний геологийн албаны дарга О.Чулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201115

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 2 дүгээр сарын 20-ны өдрийн
40 дугаар тогтоолын хавсралт

АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГГҮЙ АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООН ҮНДЭСНИЙ
ГЕОЛОГИЙН АЛБАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа (жилээр)
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт үнэ (төгрөг)	
1	Суудлын автобус Huidai County 33+1 26-65 УБҮ	2014-11-01	158,500,000.00	1	158,500,000.00	20,000,000.00	1	20,000,000.00	2
2	Тогоо /хуушуурын/	2015-05-31	200,000.00	1	200,000.00	20,000.00	1	20,000.00	1
3	Ус буцалгагч 30 литр	2015-05-31	210,000.00	1	210,000.00	10,000.00	1	10,000.00	1
4	Шарах шүүгээ-Хятад	2013-06-19	350,000.00	1	350,000.00	10,000.00	1	10,000.00	1
5	Тоос сорогч-30 L	2014-12-31	313,500.00	2	627,000.00	10,000.00	2	20,000.00	1
6	Сандал хар дугуйтай 5510л 2008	2008-03-11	95,613.00	1	95,613.00	10,000.00	1	10,000.00	1
7	Сейф хар 2 хаалгатай	2008-03-19	169,442.00	1	169,442.00	10,000.00	1	10,000.00	1
				8	160,152,055.00		8	20,080,000.00	
	НИЙТ ҮНЭ			(нэг зуун жаран сая нэг зуун тавин хоёр мянга тавин тав)				(хорин сая наян мянга)	